

НИЙТЭД ТУСТАЙ АЖИЛ ХИЙЛГЭХ ЯЛ ЭДЛҮҮЛЭХ АЖИЛЛАГААНД ТУЛГАМДАЖ БУЙ АСУУДАЛ

SENTENCING FOR PUBLIC BENEFIT WORK THE PROBLEM WITH THE JOB



Б.Эрдэнэчимэг

Өмнөговь аймгийн Ханбогд сум дахь

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх хэлтсийн

Хорихоос өөр төрлийн ял эдлүүлэх ажиллагаа

хариуцсан шийдвэр гүйцэтгэгч, ахлах дэслэгч

Товч утга: Нийтэд тустай ажил хийлгэх ял шийтгүүлсэн ялтныг ажиллуулахад анхаарах зарим асуудал, тус ялыг хэрэгжүүлдэг гадаадын улс орнуудын туршлага, нийгэмд ашигтай ажлыг судлаач эрдэмтдийн судалгаанд тулгуурлан тодорхойлох, хэрэгжилтийг хангах, шүүхийн шийдвэрийг биелүүлээгүй тохиолдолд хүлээлгэх хариуцлага, хууль, эрх зүйн зохицуулалтын хүрээнд тулгамдаж буй асуудлыг гарган, шийдвэрлэх арга замыг тодорхойлохыг зорилоо.

Түлхүүр үгс: Нийтэд тустай ажил хийлгэх ял, түүний мөн чанар, ялын зорилго, нийгэмд үйлчлэх ял.

Abstract: Some issues to be considered in the employment of convicts sentenced to community service, the experience of foreign countries that implement this sentence, the definition of socially useful work based on the research of researchers, ensuring implementation, liability in case of non-compliance with the court; and legal and regulatory issues aimed to identify the problem and solve it.

Keywords: Community service sentence , its nature, purpose of sentence, community service sentence.

Нийгмийн түүхэн хөгжлийн тодорхой үе шатуудад хүмүүс өөрсдийн амь нас, эрүүл мэндэд хохирол учруулсан этгээдүүдийн үйлдлийг нь гэмт хэрэг хэмээн үзэж, тэднийг янз бүрээр шийтгэдэг байлаа. Харин энэхүү шийтгэлийн агуулга, зорилго нь тухайн нийгмийнхээ мөн чанараас шалтгаалан өөр өөр байж ирсэн.

Гэмт хэрэг үйлдэгчдэд оногдуулах эрүүгийн ял шийтгэлийн гол хэлбэр нь хорих ял бөгөөд дэлхийн ихэнх орнуудад түгээмэл хэрэглэдэг билээ. Гэтэл сүүлийн үед дэлхийн нийтээр хорих ялын нийгэмд болон хувь хүндээ үлдээх сөрөг үр дагаврыг улам бүр ойлгон, гэмт хэрэг үйлдсэн хүнийг шоронд хорихоос өөр

байдлаар цээрлүүлэх, засч хүмүүжүүлэх, нийгэмшүүлэх арга хэлбэрийг илүү сонгох болсон дэлхий нийтийн чиг хандлагаас харагдаж байна. Тухайлбал Голланд улс анх удаа шийтгэлийн гол төрөл болох хорих ялаас татгалзсан шийдвэрийг гаргасан. Тиймээс хорихоос өөр төрлийн ялыг сонгож хэрэглэх нь үр дүнтэй байгааг тодорхойлж байгаа юм. Үүний үр дүнд хорихоос өөр төрлийн ялын нэг төрөл болох нийгэмд тустай хөдөлмөр хийлгэх буюу нийтэд тустай ажил хийлгэх ял нь эрүүгийн хариуцлагын арга хэмжээнд хамгийн үр нөлөөтөйд тооцогдож, дийлэнх улсын эрүүгийн хууль тогтоомжид тусгалаа олж, шүүн таслах үйл ажиллагааны практикт өргөн хэрэглэгдэх болсон байна.

Хорихоос өөр төрлийн ял болох нийтэд тустай ажил хийлгэх ялыг практикт зонхилон хэрэглэж байгаа хорих ялтай харьцуулбал өөрийн гэсэн эерэг олон шинжийг агуулж байгаа юм. Энэ талаар судлаачдын дүгнэлтээс иш татвал Ш.Эрдэнэбат, О.Алтангэрэл “Гэмт хэрэгтнийг хорих газраас өөр газар олон нийтэд ойр орчинд ялыг эдлүүлэх, тодорхой хяналтын дор нийгэмд ашигтай хөдөлмөр эрхлэх боломжоор хангах нь шоронжих сөрөг үр дагавраас урьдчилан сэргийлэхэд эерэг нөлөөтэй”¹⁰², профессор Б.Уранцэцэг “Гэмт хэрэг үйлдсэн этгээдийг нийгмээс тусгаарлахгүйгээр, гэр орондоо, садан төрлийн хүмүүсийнхээ дэргэд улмаар тодорхой хамт олны дунд байж тэдгээрийн дэмжлэг нөлөөн дор гэм буруугаа ойлгож, амьдралын зөв байр суурь хандлага руугаа эргэн орох боломжийг хорихоос өөр төрлийн ял болох албадан ажил хийлгэх ял олгодог”¹⁰³ Ц.Мөнхбат “Нийтэд тустай ажил хийлгэх ял шийтгүүлсэн этгээдэд цалин хөлстэй ажлыг цалин хөлс олгохгүйгээр хийж гүйцэтгүүлэх гэсэн санал агуулагдаж байна”. хэмээн тус тус дүгнэн бичсэн байна. Мөн ХБНГУ-ын Эрүүгийн ялын нэг гол зорилго нь ялтын нийгмээс тусгаарлахгүйгээр нийгэмшүүлэх асуудалд анхаарч ажилладаг нь тухайн улсын туршлагаас ажиглагдаж байна. Жишээлбэл: ХБНГУ-ын хорих байгууллагууд нь хотын төв дунд байршилтай, нийгэмшүүлэх үйл ажиллагааг зохион байгуулахдаа нийгэмд нээлттэй хэлбэрээр зохион байгуулдаг байна.

Харин манай улсын хувьд хорих ялыг хүчтэй байлгах сонирхол их байгаа нь хүмүүсийн эрх зүйн ухамсар, боловсрол дутуу дулимаг, төрийн ялын **бодлого** учир дутагдалтай, хууль сахиулах байгууллагуудын ажлын уялдаа холбоо төдийлэн сайн биш, төрийн болон иргэдийн хяналт сул байгаатай холбон үзэж болно. Өөрөөр хэлбэл, хүнд гэмт хэрэг **үйлдсэний** төлөө удаан хугацаагаар хорих нь шударга ёсыг тогтоох **явдал** гэсэн үзэл санаа нийгэмд хүчтэй байгаатай холбоотой.

Хэдийгээр нийгэмд аюултай гэмт хэрэг үйлдсэн боловч **түүндээ** тохирсон ял хүлээж байгаа нь шударга ёс бөгөөд харин ялаа эдэлж байгаа явдал нь түүнийг

¹ Ш.Эрдэнэбат, О.Алтангэрэл. Шийдвэр гүйцэтгэгчийн ном. УБ.2004 он 186 дах тал.

¹⁰³ А.Алтанзул . Албадан ажил хийлгэх ялын хэрэгжилтийн өнөөгийн байдал, түүний эрх зүйн орчинг боловсронгуй болгох зарим асуудал. 2007 он

дахин гэмт хэрэг үйлдүүлэхгүй **байхад** чиглэгдсэн хүмүүжлийн буюу урьдчилан сэргийлэх ач холбогдлоор тайлбарлах нь илүү зохистой гэж үзэж байна.

Тиймээс энэхүү илтгэлийн нэг үндсэн зорилго нь нийтэд тустай ажил хийлгэх ял, түүний мөн чанар, зорилгыг тодорхойлох ба энэ нь практикт ялыг зөв оногдуулж, түүнийг бодитой хэрэгжүүлэхэд зайлшгүй шаардагдах мэдлэг түгээхэд оршиж байгаа билээ.

Нийтэд тустай ажил хийлгэх ял нь “нийгэмд үйлчлэх ял” хэмээн зарим улс орны Эрүүгийн хуульд тусгалаа олсон байна¹⁰⁴. Нийгэмд үйлчлэх ялыг ялын мөн чанарын үүднээс холбон тайлбарлавал ялтныг хөдөлмөрөөр хүмүүжүүлэхэд оршдог гэж хэлж болно. Иймд нийгэмд үйлчлэх ялын объект нь зайлшгүй хөдөлмөр байдаг.

Нийтэд тустай ажил хийлгэх ял нь улс орнуудын Эрүүгийн хуульд ялын нэг төрөл болон хуульчлагдсан нь 19-р зууны сүүл үе, 20-р зууны эхэн үед бий болсон “нийгмийн ажил” хэмээх ухагдахуунтай салшгүй холбоотой юм. Тухайлбал, Дани улс 1930 онд Эрүүгийн хуульдаа энэ ялыг хуульчлан өгсөн нь анхдагч улсын тоонд ордог.¹⁰⁵

Нийтэд тустай ажил хийлгэх ял нь нэр томъёоны хувьд улс орон бүрт харилцан адилгүй хуульчлагдан томъёологдсон байна. Жишээлбэл: Казакстан, Киргизийн Эрүүгийн хуулиудад уг ялыг “нийгмийн ажилд татан оролцуулах” гэсэн байдаг бол Английн зарим хуульд “нийгэмд үнэ хөлсгүй үйлчлэх”, Гүржийн Эрүүгийн хуульд “нийгэмд ашигтай хөдөлмөр эрхлэх” Молдавт бол “нийгмийн тусын тулд үнэ хөлсгүйгээр ажиллах”, харин Латвийн Эрүүгийн хуульд “албадан хөдөлмөр хийх”, Францад “нийтийн ашиг сонирхлын төлөө ажил хийх”, Испанид бол “нийгмийн тусын тулд ажиллах” хэмээн тодорхойлдог. Тэгвэл **ОХУ**, Голланд, **Украин** зэрэг улсуудад нийгмийн хөдөлмөр буюу “заавал ажил хийх” **ял** гэж тус тус нэрлэгддэг байна.¹⁰⁶

Харин Нийтэд тустай ажил хийлгэх ялын гол шинжүүдээс дурдвал:

- нийгмийн болон олон нийтэд зориулагдсан шинжтэй ажил хийх
- нийгэмд ашигтай ажил байх
- албадлагын шинжтэй
- үнэ хөлсгүй хийх ажил байх гэсэн шинжүүд хамаарах юм. Энд дурдагдсан нийгмийн буюу олон нийтийн төлөө ажил хийх болон нийгэмд ашигтай ажил гэдгийг ялган авч үзэх зайлшгүй шаардлагатай байгаа юм.

Монгол Улсад хөдөлмөрлөх эрхтэй холбоотойгоор үүссэн гол гол нийгмийн харилцааг зохицуулдаг эрх зүйн үндсэн салбар бол Хөдөлмөрийн эрх

¹⁰⁴ Б.Билэгсайхан Албадан ажил хийлгэх ял бол ял шийтгэлийн өвөрмөц төрөл мөн. Улаанбаатар.2004 он. 23 дах тал

¹⁰⁵ А.Алтанзул . Албадан ажил хийлгэх ялын хэрэгжилтийн өнөөгийн байдал, түүний эрх зүйн орчинг боловсронгуй болгох зарим асуудал. 2007 он

¹⁰⁶ А.Алтанзул . Албадан ажил хийлгэх ялын хэрэгжилтийн өнөөгийн байдал, түүний эрх зүйн орчинг боловсронгуй болгох зарим асуудал. 2007 он

зүй байдаг билээ. Гэхдээ нийтэд тустай ажил хийлгэх ял шийтгүүлсэн ялтны хөдөлмөрийн харилцаа эрүүгийн эрх зүйн зохицуулалтад хамаардаг нь уг ялын объект хөдөлмөр буюу нийгэмд ашигтай хийгдэх ажил байдагтай холбоотойгоор тайлбарлагдана.

Эрүүгийн хуульд зааснаар нийтэд тустай ажил хийлгэх ялын объект болох нийгэмд ашигтай ажлыг ялтан хаана гүйцэтгэхийг шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага тогтоон ял эдлүүлэх ажиллагаанд хяналтыг хэрэгжүүлдэг. Эндээс бид нийгэмд ашигтай ажил, хөдөлмөр гэж юу болох, түүний үндсэн шинж болон төрлийн талаар авч үзье.

Ер нь хөдөлмөр гэдэг ойлголтыг хүн төрөлхтөн эртнээс нааш мэдлэгийн янз бүрийн салбаруудаар дамжуулан судалж, тодорхойлж ирсэн. Хамгийн товчхоноор хэлбэл хөдөлмөр гэдэг бол эдийн болон эдийн бус баялгийг бүтээгч хүний зорилтот үйл ажиллагаа гэж хэлж болно.

Монгол улсын Эрүүгийн хуульд нийгэмд ашигтай ажил гэж ямар шинжтэй ажил байхыг заагаагүй. Харин эрдэмтэн судлаачдын бүтээлд товчхон агуулгаар тусгагдсан байдаг. Тухайлбал, доктор, профессор Г.Совд “тухайн нутаг дэвсгэрийн

тохижилт үйлчилгээний чиглэлийн биеийн хүчний ажлуудыг”¹⁰⁷, харин хуульч Д.Дэмбэрэлцэрэн “гудамж талбай цэвэрлэх, тохижуулах, хог цэвэрлэх, булах, мод сөөг суулгаж арчлах зэрэг ажил багтана” гэсэн бол доктор, профессор Б.Уранцэцэг “нийгэмд ашигтай ажил буюу ялтны хөдөлмөрийн үр дүн нь нийтэд эсхүл тодорхой нутаг дэвсгэрийн, тодорхой бүлгийн хүн амд хүртэж байх ажлыг хэлнэ”⁸. гэж тус тус үзсэн байна. Эдгээр хүмүүс “Нийгэмд ашигтай ажил” гэдэг ойлголтын агуулгыг үндсэн шинжүүдээр нь тодорхойлсон байна.

Нийгэмд ашигтай ажил нь заавал биеийн хүчний ажлын хэлбэрээр илэрнэ гэж үзэх нь учир дутагдалтай юм. Харин ялтны хийж буй ажил нь нийт хүн ам буюу олон түмний нийтлэг хэрэгцээ шаардлагыг хангасан шинжтэй байх нь уг хөдөлмөрийн үндсэн шинж гэж үзэж болно. Иймээс Эрүүгийн хуульд “нийгэмд ашигтай” гэсэн тодотгол нь тусгагдсан гэж дүгнэж болно. Өнөөдрийн практикт аймаг, хот, сум, дүүргийн засаг даргатай гэрээ хийж хот тохижуулах газар ажиллуулж байна. “**Нийгэмд ашигтай**” ажлыг төрөлжүүлэн ангилж авч үзэж болох юм. Үүнд:

Эрүүл аюулгүй орчны таатай нөхцөл байдлыг бий болгоход чиглэсэн ажил.

Нийтийн эзэмшлийн газарт мод зүлэг тарих, усалгаа хийх зэрэг хот цэцэгжүүлэлтийн газруудад ажиллахыг хэлнэ. Өнөөдөр манай улсад энэ төрлийн үйл ажиллагаа явуулдаг төрийн өмчит “Хот цэцэрлэгжүүлэлт”, “Хот тохижилт”

¹⁰⁷ Г.Совд “тухайн нутаг дэвсгэрийн тохижилт үйлчилгээний биеийн хүчний ажил” 2002 он

⁷ Д.Дэмбэрэлцэрэн Эрүүгийн хуулийн ерөнхий анги гол гол өөрчлөлтүүд, тэдгээрийг хэрэглэх асуудлууд / Монголын төр эрх зүй 2002/2 49 дах тал

ОНӨААТҮГазар байдаг бөгөөд цаашид энэ чиглэлээр хувь хүн, хуулийн этгээдүүдийг олноор бий болгож, үүнд нь албадан ажил хийлгэх ялаар шийтгэгдсэн ялтныг ажиллуулах нөхцлийг бий болгох шаардлагатай.

Хот тохижуулах чиглэлээр, тодруулбал нийтийн эзэмшлийн газар болох гудамж талбайг орчны хогийг цэвэрлэх, хүйтний улиралд цас, мөс арилгах зэрэг орно.

Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх чиглэлийн ажил. Энд ой цэвэрлэх, нөхөн суулгах гэх мэт орно.

Нийгмийн хүмүүнлэгийн чанартай ажил хөдөлмөр.

Нийтийн сайн сайхны төлөө ажилладаг буяны болон хүмүүнлэгийн байгууллагуудад ажиллахыг хэлнэ. Жишээ нь: Улаан загалмайн нийгэмлэгт, асрамжийн байгууллагуудыг нэрлэж болно.

Гамшигт байдал буюу байгалийн давагдашгүй хүчний улмаас бий болсон нөхцөл байдлын хор уршгийг арилгахтай холбоотой чиглэсэн ажил. Үүнд: ялтан галын аюул, үер, зуд зэрэг онцгой нөхцөл байдалд ажиллах болно.

Бүтээн байгуулалтын шинжтэй буюу барилгын, аймаг, сумыг холбосон авто болон төмөр зам, гүүр барих ажлууд хийлгэж болно.

Яг ийм чиглэлээр албадан ажил хийлгэх ялаар шийтгэгсэд ажиллахгүй байгаа билээ. Энэ салбарт харьцангуй тухайн чиглэлийн мэргэжилтэй ялтнуудыг ажиллуулах нь уг этгээдэд ялын зорилго хангагдахад чухал ач холбогдолтой юм.

Ялангуяа нийтэд тустай ажил хийлгэх ялаар шийтгүүлсэн ялтны хувийн онцлог байдлыг харгалзан үзэж ямар төрлийн ажлыг хийлгэх нь ач холбогдолтой вэ гэдэг талаас нь хууль сахиулах байгууллагын ажилтан бид анхаарч ажиллах нь зүйтэй юм. Нэгэн баримт тоон үзүүлэлт авч үзэхэд нийтэд тустай ажил хийлгэх ялаар шийтгэгдсэн 42 ялтны 38 нь тохижилт үйлчилгээний компанид ажилласан байх жишээтэй байгаа юм энэ нь ялтныг хувийн болон ажил мэргэжлийн онцлог байдлыг харгалзан үзэж албадан ажил хийлгэж нийгэмшүүлэх биш цээрлүүлэх, бусдад өширхөх, нийгмийг үзэн ядах үзлийг төлөвшүүлэх эрсдэлтэй.

Ялтнаар тэгвэл ямар ажлыг хийлгэж болох вэ?

Ер нь аливаа хүний хөдөлмөр бол түүний амьд явах эрхийн баталгаа, сайн сайхан амьдрах эрхэм зорилгоо биелүүлэх үндсэн хэрэгсэл болдог. Тэгвэл нийгэмд ашигтай ажлын зорилго бол нийтийн сайн сайхны төлөө, тэдгээрийн эрүүл аюулгүй орчныг бий болгох, хамгаалах, хадгалагдахад чиглэсэн байх ёстой билээ.

Иймд нийгэмд ашигтай ажлын үндсэн шинжийг бид тодорхойлохдоо нийтийн ашиг сонирхлын дагуу бүтээн байгуулалтын болон хамгаалалтын шинжтэй хөдөлмөр байна гэж үзэж байна. Энэхүү нийгэмд ашигтай ажлыг төрийн ба төрийн бус байгууллага, нийтэд үйлчилдэг аж ахуй нэгжүүдийн алинд ч хийж гүйцэтгэж болно. Өөрөөр хэлбэл, тухайн аж ахуйн нэгж, байгууллагад нийтэд тустай ажил хийлгэж буй ялтнаар ажил хийлгэхдээ өөрсдийн эрхэм зорилгод тусгасан нийтэд үйлчилдэг шинж чанартай ажлуудыг л гүйцэтгүүлэх ёстой.

Тулгамдаж буй асуудлын талаар

1. Нийслэл болон орон нутгийн шүүхээс гүйцэтгэх баримт бичгийг ялтан, этгээдгүй ирүүлдэг
2. ШШГТХууль болон холбогдох бусад хууль, журамд эрэн сурвалжлан олж тогтоосон ялтан, этгээдийг түр хугацаагаар саатуулах зохицуулалт байхгүй
3. Шөнийн цагаар болон амралтын өдрүүдэд эрэн сурвалжилж, олж тогтоосон ялтныг саатуулах, ял солих зохицуулалт байхгүй
4. Ялын цаг бүртгэлийн системд орчин үеийн дэвшилтэд технологийг нэвтрүүлэх, систем хөгжүүлэлт хийх, боловсронгуй болгох
5. Шүүхээс нийтэд тустай ажил хийлгэх ялаар шийтгүүлсэн зарим орон нутгийн харьяатай ялтнуудыг тухайн сум, орон нутагт нь ялыг эдлүүлэхэд ажлын байр байгаа боловч тэдэнд хяналт тавихад шийдвэр гүйцэтгэх ажиллагааны зардал байхгүй.
6. Сумдад нийтэд тустай ажил хийлгэх ялаар шийтгүүлсэн ялтны ял эдлэлтийн байдалд аймгийн хуулийн хэлтэс хянаж шалгах үүрэгтэй боловч практикт хэрэгждэггүй
7. “Нийгэмд ашигтай ажил” гэсэн тодорхойлолтыг эрх зүйн талаас тодорхойлоогүй тул орон нутагт ялтнаар ямар ажил хийлгэх вэ гэдэг нь бүрхэг байдгаас уг ялын зорилго хангагддаггүй.

Санал

1. Нийтэд тустай ажил хийлгэх ялын хэрэгжилтэд цаашид анхаарах асуудалд судлаачийн зүгээс дараах саналыг дэвшүүлж байна. Үүнд:
2. Нийтэд тустай ажил хийлгэх ялыг хуулийн дагуу хэрэгжүүлэхэд тусгайлсан алба, мэргэжлийн ажилтныг ажиллуулах талаар орон нутагт ажлын байр бий болгож, байгууллагын бүтэц орон тоог нэмэгдүүлэх /нийгмийн ажилтан, сэтгэл зүйч/
3. ШШГТХууль болон холбогдох бусад хууль, журамд эрэн сурвалжлан олж тогтоосон ялтан, этгээдийг түр хугацаагаар саатуулах болох,
4. Шөнийн цагаар болон амралтын өдрүүдэд эрэн сурвалжилж, олж тогтоосон ялтныг саатуулах, ял солих зохицуулалттай болох,
5. Эрүүгийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааны зардал, төсөвтэй болох
6. Нийтэд тустай ажил хийлгэх ялын талаар хууль сахиулах байгууллага болон холбогдох захиргааны байгууллага, ажил олгогч, аж ахуйн нэгж, байгууллагын удирдлага, уг ялыг эдлүүлэх ажиллагаатай холбоотой мэдээлэл сурталчилгаа, сургалтыг зохион байгуулах
7. Төрийн болон орон нутгийн өмчит аж ахуйн үйлдвэрийн газарт ажиллуулах,
8. Үндэсний брэнд бүхий үйлдвэртэй болох, үйлдвэрийг үнэгүй, хямд ажиллах хүчээр хангах
9. Нийтэд тустай ажил хийлгэх ял шийтгүүлсэн ялтныг ажлын байраар хангах хөдөлмөр, нийгмийн харилцааг тодорхой боловсронгуй болгох, ял эдлэх хугацаанд ялтан орлого олох боломжгүй байдаг тул ажил олгогч, байгууллагаас ялтанд унааны болон өдрийн хоолны мөнгө гаргуулдаг байх

зэрэг болно.

Ашигласан эх сурвалжийн жагсаалт:

1. Монгол улсын Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль 2017 он
2. Монгол улсын Эрүүгийн хууль 2015 он
3. А.Алтанзул . Албадан ажил хийлгэх ялын хэрэгжилтийн өнөөгийн байдал, түүний эрх зүйн орчныг боловсронгуй болгох зарим асуудал. 2007 он
4. Д.Дэмбэрэлцэрэн Эрүүгийн хуулийн ерөнхий ангихол гол өөрчлөлтүүд, тэдгээрийг хэрэглэх асуудлууд / Монголын төр эрх зүй 2002/2
5. Б.Уранцэцэг Албадан ажил хийлгэх ял бүхий ялтныг ажиллуулахад анхаарах зарим асуудлаас / Хүний эрх сэтгүүл. 2005 он № 3.
6. Б.Билэгсайхан Албадан ажил хийлгэх ял бол ял шийтгэлийн өвөрмөц төрөл мөн. Улаанбаатар.2004 он.
7. Ш.Эрдэнэбат, О.Алтангэрэл. Шийдвэр гүйцэтгэгчийн ном. УБ.2004 он
8. О.Пүрэвсүрэн Албадан ажил хийлгэх ялыг эдлүүлэх үед анхаарах зарим асуудлууд. Зөвлөмж 2004 он
9. Б.Алтангэрэл “Хорихоос өөр төрлийн ял эдлүүлэх ажиллагаа хэрэгжилт, чиг хандлага” эрдэм шинжилгээний хурлын эмхэтгэл 2018 он

---o0o---